



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: [Selenge@audit.gov.mn](mailto:Selenge@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**БАРУУНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-ШТА-НА-21  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.


## Дүгнэлт

Ардчилсан намын Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баруунбүрэн сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр ( .....<sup>3</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баруунбүрэн сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Баруунбүрэн сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн гол зорилго нь Ардчилсан намаас дэвшүүлсэн “Шинэ бодлого-Шинэ хөгжил” хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт мөрийн хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг, нийгэм, засаглалын 3 тулгуурт бодлогыг хэрэгжүүлэн төрөлжсөн эдийн засагтай, чанартай, хүртээмжтэй, нийгмийн суурь үйлчилгээг үзүүлсэн шударга засаглал бүхий улсын тэргүүний сум болоход оршино.

**НЭГ. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

- 1.1. Тус сумын гол үндсэн үйлдвэрлэл болох газар тариалан, мал аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж, Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгон хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулна.
- 1.2. Тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах шашин номын төв Амарбаясгалант хийдийг зорин очих сүсэгтэн олон болон гадаад, дотоодын аялал жуулчлалын тоог нэмэгдүүлэх зорилгоор тавигдаж эхэлсэн Дархан-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замаас Амарбаясгалант хийд хүртэлх 33.4 км авто замыг ашиглалтад оруулах талаар Засгийн газар болон холбогдох яамдад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.3. Төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүдийн цэвэр усны болон бохир зайлуулах нэгдсэн байгууламжтай болно.
- 1.4. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг зүй зохистой ашиглан хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт зорилтын дагуу иргэдийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломжоор бүрэн хангаж, хүнсний ногоо даршлах, нөөшлөх, савлах, жижиг оврын тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5. Газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжийн тариалангийн талбайг бүрэн хашаажуулж, малчид, тариаланчдын хоорондын зөрчлийг арилгахын зэрэгцээ тэдгээрийн уялдаа, холбоог сайжруулж, газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжүүдтэй хамтран тэжээлийн ургамал тариалахад зөвлөн тусална.
- 1.6. Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан малгүй өрхийг малжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өрх бүрийг бүрэн малжуулах зорилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

## ХОЁР. НИЙГЭМ

2.1. Сумын төв, гэр хорооллын хооронд зам засварын ажлыг хийж, усжуулах фермийн хороололд үерийн далан шинээр барьж байгуулах, асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилгын асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.3. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд "Хан Бүрэн Шим Трейд ХХК"-тай хамтран, 12 айлын орон сууцыг шинээр барьж байгуулна.

2.4. Моностойн амралт орчмын цахилгааны шугамыг түшиглэн, Бургалтайн 2 дугаар багийн төвийг Хуучин төвд барьж байгуулах ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр уламжилж, багийн дарга, эмч, байгаль хамгаалагч, малын эмч нарыг багийн иргэд, малчидтай ойртуулан ажиллах боломжийг бүрдүүлнэ.

2.5. Тус сумын малчдын сүүг борлуулах зорилгоор Хатан Мээж ХХК-тай хамтран сумын төв, Бургалтайн 2 дугаар багийн нутаг Хуучин төвд сүү хүлээн авах тоног төхөөрөмжийг суурилуулан, малчдын сүүг зах зээлд нийлүүлэх аятай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Сурагчдын сурах орчныг сайжруулан, багш нарын ур чадвар, багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч, сурагчдын сурлагын түвшнийг дээшлүүлнэ.

2.7. Соёлын төвийг мэргэжлийн хөгжмийн болон бүжгийн багштай болгож, боловсон хүчнийг чадваржуулахад анхаарна.

## ГУРАВ. ЗАСАГЛАЛ

3.1. Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадвартай, албан тушаалаас үл хамаарч хуулийн өмнө тэгш хариуцлага хүлээдэг, мэргэжлийн, хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлж, шинэчлэл хийн орон нутагтаа бүтээлч, бүтээгч засаглалыг бий болгоход анхаарч ажиллана.

3.2. Малын хулгай болон бусад гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг судалж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийг татан оролцуулж, малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулан, дундын сан бий болгон малын хулгайтай тэмцэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

3.3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ойн нөөцгүй сумдад олгогдох түлшний болон хэрэглээний модны хуваарийг багасгах тухай саналыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлж,



ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангуулахад анхаарч ажиллана.

3.4. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан ногоон эдийн засагт суурилсан, аливаа үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Бүрэнхан уулынхаа жимс жимсгэнэ, байгалийн дагалдах баялгийг зөвхөн нутгийн иргэдэд ашиглуулах асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.5 1992 онд Бугын аж ахуй байгуулах нэрийн дор Ивэнгийн 1 дүгээр багийн нутаг Азрын хошуу, Ар могой, Тойлбын давааны ар зэрэг 30.0 гаруй мянган га бэлчээрийн нутгийг Хушаат суманд шилжүүлснийг сумын мэдэлд эргүүлэн авах талаар УИХ, Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлнэ.

3.6 Тус сумын 2 дугаар багийн алслагдсан нутаг Арцдын даваа, Хангалын адаг, Уртын гол, Ямаатын даваа, Хонгор овооны хөндий, Цалгарын ам, Илжгэн харанхуй зэрэг 40.0 гаруй мянган га газарт Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын мал бүхий 30 гаруй малчин өрхийн 25.0 мянган толгой мал өвөлжиж, хаваржиж байгааг нүүлгэн шилжүүлэх, газар нутгаа чөлөөлүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан, өөрийн сумын малчдыг эзэмших, ашиглах эрхийг бүрдүүлж, худаг ус гаргах асуудлыг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



**Б А Р У У Н Б Ü Р Э Н С У М Ы Н А Р Д Ч И Л С А Н Н А М Ы Н Х О Р О О**